ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

УВС-2015/11/СТА-ТШЗ

АУДИТЛАГДСАН ТАЙЛАНГИЙН НЭР — **УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

ТАЙЛАНГИЙН ХУГАЦАА — **2014 ОНЫ ТӨСВИЙН ТАЙЛАНТ ЖИЛ**

БЭЛТГЭСЭН — **ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

2015 оны 01 дүгээр сарын 29

Улаангом

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
УВС АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2015.02.02 № УВС-2015/111/СТИ-ТШЗ

танай -ны № -т

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Ж.ЭРДЭНЭСҮРЭН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу ҮАГ-ын харьяа Увс аймгийн Аудитын газраас аудит хийв.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын батлсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын батлсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Б.АВИРМЭД/

0300039

УААГ

Увс аймгийн Аудитын газар

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор: Б.Авирмэд
Утас: 70453317

Аудитын менежер: С.Батжаргал
Утас: 70453721

Ахлах аудитор: С.Алтанхундага
Утас: 70453799

Аймгийн аудитын газар

АЗДТГ-ын байр
Улаангом сум
Увс аймаг
Монгол Улс

2015 оны 1 дүгээр сар 29

рим,

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /УВС-/2015/11/СТА-ТШ3 / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 1 дүгээр сарын 24-наас 2015 оны 1 дүгээр сарын 29–ний хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын харьяа Увс аймгийн Аудитын газрын ахлах аудитор С.Алтанхундага хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланг 2015 оны 1 дүгээр сарын 24-нд төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

ҮАГ-ын харьяа Увс аймгийн Аудитын газар аудитыг 2015 оны 1 дүгээр сарын 24-наас 2014 оны 1 дүгээр сарын 29-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2014 оны 2 дүгээр сарын 02-нд Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн захирагч нь Монгол улсын Статистикийн тухай хууль,Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Татварын багц хууль,Төсвийн тухай хууль,Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж

түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, статистикийн байгууллага, мэдээлэгчийн бүрэн эрхийг тогтоож, тэдгээрийн хооронд болон хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино. Статистикийн байгууллагын зорилго нь "Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон статистикийн үнэн бодит мэдээлэл судалгаагаар төр засаг, иргэд, байгууллагад нэгэн адил үйлчлэх" гэж заасан байна. Тухайн байгууллага 2014 оны зорилтоо: "орон нутгийн Статистикийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх, хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн баазыг бий болгох, тооллого, түүвэр судалгаануудыг хугацаанд нь зохион байгуулж үр дүнг шуурхай мэдээлж байх" гэж үйл ажиллагааны зорилтоо тодорхойлжээ.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д "төсвийн байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна" гэж заасны дагуу Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Статистикийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 17-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулагдаж гараагүй байна. ОУ-ын стандарттай нийцсэн нягтлан бодох бүртгэлийн программтай байна.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд энгийн буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Монгол Улсын Үндэсний статистикийн газраас санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн захирагч нь 2014 онд улсын төсвөөс урсгал зардалд 77804.0 мянган төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтаар Үндэсний статистикийн газар, хорооноос судалгаа шинжилгээ төсөл арга хэмжээний зардалд 125689.6 мянга, орон нутгийн нөөц хөрөнгөөс 1622.6 мянган төгрөгийн орлого санхүүжилт олжээ. Үүнээс урсгал зардалд 215043.4 мянган төгрөгийг зарцуулж, МУ-ын Үндэсний статистикийн газарт 3162.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оны 1 дүгээр сарын 29-ны байдлаар батлагдсан төсвөө shilendans.gov.mn сайтад байршуулсан байна. Хуулийн хэрэгжилтийн эхний жил тул бусад тайлан мэдээллээ бүрэн оруулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хангамжийн материал, бусад орлого, цалин, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, гэрэл цахилгаан, төлбөр хураамж, албан томилолт зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг нарийвчилсан горим сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй бөгөөд Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1 Статистикийн хэлтсийн үндсэн үйл ажиллагааны 150026001 тоот дансны жилийн эцсийн үлдэгдэл 2835150.32, нэмэлт санхүүжилтийн 150026401 тоот дансанд 327754 төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаар тайлагнасан байна. Төсвийн тухай хуулийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй байсанд тайланд залруулга хийлгэлээ.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгож. Санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

2.Нэр дансны зөрүүтэй гүйлгээний 20.0 мянган төгрөгийг Үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан байна. УСНББОУС 9, 23, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1-р хавсралтын 2.1-д "тайлангийн хугацаанд байгууллагын ердийн үйл ажиллагааны үр дүнд орж ирж байгаа бөгөөд өмчлөгчдөөс оруулах нэмэгдэл хөрөнгө оруулалтаас бусад цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхиа орох нийт орлогын урсгалыг орлого гэнэ" гэснийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгож. Санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулаагүй алдаа илрээгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад асуудал гараагүй бөгөөд харилцах дансны хууллагыг тайлант үеийн тасалбар болгосон хугацаанд авч байхыг аудитын явцад зөвлөмж болголоо.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад орлого, үндсэн хөрөнгө, бараа материалын тайлагналыг эрсдэлтэй гэж үзэж байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3182.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг тайланд залруулга хийлгэсэн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2013 оны санхүүгийн тайланд Увс аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмжийн утга	Хэрэгжсэн эсэх
Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг мөрдөн ажиллах.	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.
Хуучин тавьсан сэлбэг хэрэгслийг солихдоо комиссын актыг үйлдэж байх.	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.
Төсвийн тухай хуулийг мөрдөн ажиллах.	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, хавсралтууд хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Б.АВИРМЭД/

АУДИТЫН МЕНЕЖЕР /С.БАТЖАРГАЛ/

БЭЛТГЭСЭН: **АХЛАХ АУДИТОР** /С.АЛТАНХУНДАГА/

Огноо: 2015.01.29

УАА Г

Увс аймгийн Аудитын газар

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:
Тэргүүлэх аудитор: Б.Авирмэд
Утас: 70453317

Аудитын менежер: С.Батжаргал
Утас: 70453721

Ахлах аудитор: С.Алтанхундага
Утас: 70453799

Аймгийн аудитын газар

АЗДТГ-ын байр
Улаангом сум
Увс аймаг
Монгол Улс

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Мөнгөн хөрөнгө.....2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Орлого 3

2015 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Увс аймгийн Аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Төрийн аудитын байгууллагын энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Мөнгөн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №1

УВС-АГ-ын ажиглалт

Статистикийн хэлтсийн үндсэн үйл ажиллагааны 150026001 тоот дансны жилийн эцсийн үлдэгдэл 2835150.32, нэмэлт санхүүжилтийн 150026401 тоот дансанд 327754 төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаар тайлагнасан байна. Төсвийн тухай хуулийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй байсанд тайланд залруулга хийлгэлээ.

УВС-АГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 45.2- дахь заалтыг мөрдөж ажиллах.

Эрсдэлүүд

Хөрөнгө биетээр байгаагаар бүртгэгдэж, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

/ОБ, ЭҮ, ИБ, ҮЗ/

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч тайланд залруулга хийлээ.

Асуудал 1: Орлого	Тэргүүлэх ач холбогдол №2

УВС-АГ-ын ажиглалт

Нэр дансны зөрүүтэй гүйлгээний 20.0 мянган төгрөгийг Үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан байна. УСНББОУС 9, 23, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1-р хавсралтын 2.1-д "тайлангийн хугацаанд байгууллагын ердийн үйл ажиллагааны үр дүнд орж ирж байгаа бөгөөд өмчлөгчдөөс оруулах нэмэгдэл хөрөнгө оруулалтаас бусад цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхиас орох нийт орлогын урсгалыг орлого гэнэ" гэснийг зөрчиж байна.

УВС-АГ-ын зөвлөмж

УСНББОУСтандарт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах.

Эрсдэлүүд

Орлого, зардал хийсвэрээр нэмэгдэх, буруу илэрхийлэгдэх УСНББОУС, Сангийн сайдын баталсан заавар журам зөрчигдөх.

/ОБ, ЭҮ, ТБ, ТИ, ҮЗ/

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч тайланд залруулга хийсэн болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Б.АВИРМЭД/

АУДИТЫН МЕНЕЖЕР /С.БАТЖАРГАЛ/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР /С.АЛТАНХУНДАГА/

Огноо:2015.01.29

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны санхүүгийн байдлын аудитлагдсан тайлан

БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	Залруулга		Эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
			ДТ	КТ		
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨ	81,652.00	3,182,904.32		3,182,904.32	81,652.00	(0.00)
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-			-	-
Жижиг мөнгөн сан	-	-			-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөг	81,652.00	3,182,904.32		3,182,904.32	81,652.00	(0.00)
/валютаар/	-	-			-	-
Богино хугацаат хадгаламж	-	-			-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-			-	-
АВЛАГА	-	80,000.00			-	80,000.00
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-			-	-
ажиллагчидтай холбогдсон авлага	-	80,000.00			-	80,000.00
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	-	-			-	-
Урьдчилгаа тооцоо	-	-			-	-
Урьдчилж гарсан зардал	-	-			-	-
БАРАА МАТЕРИАЛ	5,556,168.44	5,950,368.44			5,556,168.44	5,950,368.44
Бэлэн бүтээгдэхүүн	-	-			-	-
Хангамжийн материал	5,556,168.44	5,950,368.44			5,556,168.44	5,950,368.44
Мал, амьтад	-	-			-	-
Бусад	-	-			-	-
НӨӨЦИЙН БАРАА	-	-			-	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,637,820.44	9,213,272.76		3,182,904.32	5,637,820.44	6,030,368.44
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	-	-			-	-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,134,112.66	28,664,377.97			37,134,112.66	28,664,377.97
Биет хөрөнгө	37,134,112.66	28,664,377.97			37,134,112.66	28,664,377.97
Барилга, байгууламж	-	-			-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-			-	-
Авто тээврийн хэрэгсэл	40,893,336.00	40,893,336.00			40,893,336.00	40,893,336.00
Хуримтлагдсан элэгдэл	(14,359,132.31)	(21,810,965.10)			(14,359,132.31)	(21,810,965.10)
Машин, тоног төхөөрөмж	32,037,246.54	33,887,246.54			32,037,246.54	33,887,246.54
Хуримтлагдсан элэгдэл	(26,260,412.95)	(28,263,713.96)			(26,260,412.95)	(28,263,713.96)
Тавилга, аж ахуйн зд хэрэгсэл	7,750,542.65	7,750,542.65			7,750,542.65	7,750,542.65
Хуримтлагдсан элэгдэл	(2,927,467.27)	(3,792,068.16)			(2,927,467.27)	(3,792,068.16)
Биет бус хөрөнгө	-	-			-	-
Програм хангамж	450,000.00	450,000.00			450,000.00	450,000.00
Хасагдуулга	(450,000.00)	(450,000.00)			(450,000.00)	(450,000.00)
БУСАД ХӨРӨНГӨ	-	-			-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	37,134,112.66	28,664,377.97			37,134,112.66	28,664,377.97
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	42,771,933.10	37,877,650.73		3,182,904.32	42,771,933.10	34,694,746.41
Богино хугацаат өр төлбөр	-	-			-	-
Өглөг	-	-			-	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙ	-	-			-	-
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮ	-	-			-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-			-	-
Засгийн газрын оруулсан капитал	82,297,185.54	84,147,185.54			82,297,185.54	84,147,185.54
Өмнөх үеийн үр дүн	(42,155,373.91)	(42,155,373.91)			(42,155,373.91)	(42,155,373.91)
Тайлант үеийн үр дүн	-	(6,744,282.37)		3,182,904.32	-	(9,927,186.69)
Дахин үнэлгээний зөрүү	2,630,121.47	2,630,121.47			2,630,121.47	2,630,121.47
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	42,771,933.10	37,877,650.73		3,182,904.32	42,771,933.10	34,694,746.41
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМ	42,771,933.10	37,877,650.73		3,182,904.32	42,771,933.10	34,694,746.41

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны санхүүгийн үр дүнгийн аудитлагдсан тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлангийн үлдэгдэл	Аудитын залруулга		Аудитлагдсан үлдэгдэл
		ДТ	КТ	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	-			-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-			-
Улсын төсвөөс	77,804,000.00			77,804,000.00
Урсгал	77,804,000.00			77,804,000.00
Орон нутгийн төсвөөс	-			-
Бусад төсөвт байгууллагаас	-			-
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний	127,332,213.00		20,000.00	127,312,213.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	127,332,213.00		20,000.00	127,312,213.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-			-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	205,136,213.00		20,000.00	205,116,213.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-			-
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	111,166,554.00			111,166,554.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	99,535,233.00			99,535,233.00
Цалин	61,306,967.00			61,306,967.00
Гэрээтийн цалин	38,228,266.00			38,228,266.00
Бусад нэмэгдлүүд	-			-
Унаа, болон бусад нөхөн олговор	-			-
Нийгмийн хамгааллын шимтгэл	11,631,321.00			11,631,321.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	11,631,321.00			11,631,321.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	11,631,321.00			11,631,321.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-			-
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-			-
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-			-
Эрүүл мэндийн даатгалын хураамж	-			-
Бараа үйлчилгээний урсгал зардал	98,907,441.37	3,162,904.32		102,070,345.69
Бусад бараа үйлчилгээний зардал	98,907,441.37	3,162,904.32		102,070,345.69
Бичиг хэргийн материал	494,450.00			494,450.00
Тээвэр, шатахууны зардал	23,223,759.00			23,223,759.00
Шуудан холбооны зардал	1,665,175.68			1,665,175.68
Дотоод томилолтын зардал	3,191,000.00			3,191,000.00
Сургалт семинарын зардал	-			-
Эрдэм шинжилгээний ажлын зардал	52,127,216.00			52,127,216.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	7,886,106.00			7,886,106.00
Урсгал засварын зардал	-			-
Элэгдлийн зардал	10,319,734.69			10,319,734.69
төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,162,904.32		3,162,904.32
Хөтөлбөр арга хэмжээний зардал	-			-
Төсвийн хуваарилагдаагүй зардал	-			-
Бусад төсөл арга хэмжээ	-			-
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	1,806,500.00			1,806,500.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	1,806,500.00			1,806,500.00
Мөнгөн хэлбэрээр	1,806,500.00			1,806,500.00
Нэг удаагийн тэтгэмж	1,806,500.00			1,806,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	211,880,495.37	3,162,904.30		215,043,399.69
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(6,744,282.37)		3,182,904.32	(9,927,186.69
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-			-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-			-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(6,744,282.37)		3,182,904.32	(9,927,186.69

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны мөнгөн гүйлгээний аудитлагдсан тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлангийн үлдэгдэл	Аудитын залруулга		Аудитлагдсан үлдэгдэл
		ДТ	КТ	
Тусламж, санхүүжилтын орлого	77,804,000.00			77,804,000.00
Улсын төсвөөс	77,804,000.00			77,804,000.00
Урсгал	77,804,000.00			77,804,000.00
Орон нутгийн төсвөөс	-			-
Бусад төсөвт байгууллагаас	-			-
Бараа, үйлчилгээний орлого	127,332,213.00		20,000.00	127,312,213.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	127,332,213.00		20,000.00	127,312,213.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	127,332,213.00		20,000.00	127,312,213.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-			-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	205,136,213.00		20,000.00	205,116,213.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	106,250,630.00			106,250,630.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	96,089,076.00			96,089,076.00
Цалин	50,259,280.00			50,259,280.00
Гэрээтийн цалин	43,125,557.00			43,125,557.00
Бусад нэмэгдлүүд	2,704,239.00			2,704,239.00
Унаа, болон бусад нөхөн олговор	2,704,239.00			2,704,239.00
Нийгмийн хамгаллын шимтгэл	10,161,554.00			10,161,554.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	10,161,554.00			10,161,554.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	10,161,554.00			10,161,554.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-			-
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-			-
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-			-
Эрүүл мэндийн даатгалын хураамж	-			-
Бараа үйлчилгээний урсгал зардал	93,977,830.68	3,162,904.32		97,140,735.00
Бусад бараа үйлчилгээний зардал	93,977,830.68	3,162,904.32		97,140,735.00
Бичиг хэргийн зардал	610,950.00			610,950.00
Тээвэр, шатахууны зардал	23,446,459.00			23,446,459.00
Шуудан, холбооны зардал	1,665,175.68			1,665,175.68
Дотоод томилолтын зардал	3,191,000.00			3,191,000.00
Сургалт семинарын зардал	-			-
Эрдэм шинжилгээний ажлын зардал	57,123,140.00			57,123,140.00
Жижиг зд хогшил худалдан авах зардал	-			-
Жижиг зд хогшил худалдан авах \Бага үнэ тургэн з	-			-
Төлбөр хураамж, жижиг татварууд	7,886,106.00			7,886,106.00
Төлбөр хураамж бусад зардал	7,886,106.00			7,886,106.00
Урсгал засварын зардал	55,000.00			55,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,162,904.32		3,162,904.32
Хөтөлбөр арга хэмжээний зардал	-			-
Бусад төсөл арга хэмжээ	-			-
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	1,806,500.00			1,806,500.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,806,500.00			1,806,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	202,034,960.68	3,162,904.32		205,197,865.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,101,252.32		3,162,904.32	(81,652.00)
Хөрөнгийн орлого	-			-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙ	-			-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,101,252.32		3,162,904.32	(81,652.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	81,652.00			81,652.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгд	3,182,904.32		3,162,904.32	

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны өмчийн өөрчлөлтийн аудитлагдсан тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
ДАНС	ДТ(5101)	КТ(5104)	510301+510302	КТ(5104)+*
2013 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	37,984,460.85	-	377,857.90	38,362,318.75
2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	82,297,185.54	2,630,121.47	(42,155,373.91)	42,771,933.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	82,297,185.54	2,630,121.47	(42,155,373.91)	42,771,933.10
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	1,850,000.00	-	(9,927,186.69)	(8,077,186.69)
2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	84,147,185.54	2,630,121.47	(52,082,560.60)	34,694,746.41

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗӨЭЛИЙН Д	205,061,170.00	205,197,865.00	(136,695.00)	100.1
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	205,061,170.00	205,197,865.00	(136,695.00)	100.1
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	205,061,170.00	205,197,865.00	(136,695.00)	100.1
Бараа, үйлчилгээний зардал	203,248,970.00	203,391,365.00	(142,395.00)	100.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,813,007.00	96,089,076.00	2,723,931.00	97.2
Үндсэн цалин	51,214,700.00	50,259,280.00	955,420.00	98.1
Гэрээтийн цалин	44,574,307.00	43,125,557.00	1,448,750.00	96.7
Унаа, болон бусад нөхөн олговор	3,024,000.00	2,704,239.00	319,761.00	89.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	10,232,952.00	10,161,554.00	71,398.00	99.3
Тэтгэврийн даатгал	10,232,952.00	10,161,554.00	71,398.00	99.3
Бараа, үйлчилгээний бусад зардал	94,203,011.00	97,140,735.00	(2,937,724.00)	103.1
Бичиг хэрэг	688,000.00	127,332,213.00	77,050.00	88.8
Тээвэр (шатахуун)	23,454,715.00	23,446,459.00	8,256.00	100.0
Шуудан холбоо	1,581,360.00	1,665,175.68	(83,815.68)	105.3
Дотоод албан томилолт	3,224,000.00	3,191,000.00	33,000.00	99.0
Эрдэм шинжилгээний ажил	57,368,430.00	57,123,140.00	245,290.00	99.6
Урсгал засвар	-	55,000.00	(55,000.00)	-
Төлбөр хураамж болон бусад зардал	7,886,506.00	7,886,106.00	400.00	100.0
Төлбөр хураамж бусад зардал	7,886,506.00	7,886,106.00	400.00	100.0
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,162,904.32	(3,162,904.32)	-
Татаас ба урсгал шилжүүлэг	1,812,200.00	1,806,500.00	5,700.00	99.7
Өрх гэрт олгох шилжүүлэг	1,812,200.00	1,806,500.00	5,700.00	99.7
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,812,200.00	1,806,500.00	5,700.00	99.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	205,116,173.00	205,116,213.00	(40.00)	100.0
Төсвөөс санхүүжих	77,803,960.00	77,804,000.00	(40.00)	100.0
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт	127,312,213.00	127,312,213.00	-	100.0
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	81,652.00	(81,652.00)	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСАД БҮГД	6.00	6.00	-	100.0
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.0
СУРАЛЦАГСАД /жилийн дундаар/	-	-	-	-
Ерөнхий боловсролын сургуульд суралца	-	-	-	-

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны авлагын аудитлагдсан тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
Байгууллагаас авах авлага	0	1,410,000.00	1,330,000.00	80,000.00
Төлбөртэй үйлчилгээний авлага		-	-	-
ЭМДШ-ийн тооцоо	0	-	-	-
ХАОАТ-ын тооцоо		-	-	-
Бусад		1,410,000.00	1,330,000.00	80,000.00
		-	-	-
Хүмүүсээс авах авлага	0	-	-	-
Дараа тайлангаар	0	-	-	-
Дутагдал шамшигдал	0	-	-	-
	0	-	-	-
ДҮН	0	1,410,000.00	1,330,000.00	80,000.00

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны өглөгийн аудитлагдсан тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
НДШ	0	23,920,097.00	23,920,097.00	0
Цалингийн өглөг	0	109,290,329.00	109,290,329.00	0
Ажиллагсадтай холбоотой зарда	0	-	-	0
ХАОАТ	0	9,091,615.00	9,091,615.00	0
Бараа үйлчилгээний зардал	0	3,095,103.00	3,095,103.00	0
Гэрэл цахилгааны тооцоо	0	-	-	0
Түлш халаалтын тооцоо	0	-	-	0
Шуудан холбооны тооцоо	0	503,903.00	503,903.00	0
Цэвэр, бохир усны тооцоо	0	-	-	0
Тээвэр шатахуунын тооцоо	0	1,868,250.00	1,868,250.00	0
Дотоод албан томилолтын тооцо	0	-	-	0
Хоолын тооцоо	0	-	-	0
Эмийн тооцоо	0	-	-	0
Урсгал засварын тооцоо	0	-	-	0
Байрны түрээсийн тооцоо	0	-	-	0
Бусад зардлын тооцоо	0	-	-	0
Бусад өглөг	0	722,950.00	722,950.00	0
	0	-	-	0
	0	-	-	0
	0	-	-	0
Зээл	0	-	-	0
Хүмүүстэй хийх тооцоо	0	-	-	0
Дутагдал төлбөр	0	-	-	0
Урьдчилгаа	0	-	-	0
Бусад суутган төлбөр	0	-	-	0
ДҮН	0	145,397,144.00	145,397,144.00	0

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны бараа материалын аудитлагдсан тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Бичиг хэргийн материал	Аж ахуйн материал	Сэлбэг хэрэгсэл	Түлш шатах тослох материал	Барилгын засварын материал	Хүнсний материал	Багаа боодол	Бусад хангамжийн материал	Бусад материал	Дүн
МАТЕРИАЛЫН ДАНС	350401	350402	350403	350404	350405	350406	350408	350409	3506	-
ОНЫ ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	22,500.00	2,393,569.00	260,000.00					2,880,099.44		5,556,168.44
НЭМЭГДСЭН	600,950.00			1,984,750.00						2,585,700.00
ХУДАЛДАН АВСАН	600,950.00			1,984,750.00						2,585,700.00
Төсвийн хөрөнгөөр	600,950.00			1,984,750.00						2,585,700.00
Өөрийн хөрөнгөөр										-
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АВСАН										-
Төсөвт байгууллагаас										-
Бусад байгууллагаас										-
БУСАД										-
Тооллогоор илэрсэн										-
Үний зөрүү										-
Шилжүүлэн авсан										-
Шилжүүлэн авсан /бүтцийн өөрчлөлтөөр/										-
Үндсэн хөрөнгийн устгалаас орлогодсон										-
Бусад байгууллагаас										-
ХАСАГДСАН	484,450.00			1,707,050.00						2,191,500.00
Зарцуулсан	484,450.00			1,707,050.00						2,191,500.00
ХУДАЛДСАН										-
Төсөвт байгууллагад										-
Бусад байгууллагад										-
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ШИЛЖҮҮЛСЭН										-
Төсөвт байгууллагад										-
Бусад байгууллагад										-
БУСАД										-
Акталж, устгасан										-
Тооллогоор дутагдсан										-
Үнийн зөрүү										-
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	139,000.00	2,393,569.00	260,000.00	277,700.00				2,880,099.44		5,950,368.44

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2014 оны үндсэн хөрөнгийн аудитлагдсан тайлан

Үзүүлэлт	Барилга байгууламж	Авто тээврийн хэрэгсэл	Тоног төхөөрөмж	Тавилга хэрэгсэл	Номын фонд	Бусад үндсэн хөрөнгө	Програм хангамж	Бусад биет бус хөрөнгө	ДҮН
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНС	9020101+*	39020201	39020301	39020401	39020803	39020801	39030101	01+39030301	
ОНЫ ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ		40,893,336.00	32,037,246.54	7,750,542.65			450,000.00		81,131,125
НЭМЭГДСЭН			1,850,000.00						1,850,000
Худалдан авсан, бэлтгэсэн									
Төсвийн хөрөнгөөр									
Өөрийн хөрөнгөөр									
Бусад 1									
Тусламж, хандиваар авсан			1,850,000.00						1,850,000
Гадаадын зээл, тусламжаар									
ЗГ-ын нөөц, хуваарилагдаагүй зардлаас									
ААН									
Олон нийтийн байгууллагаас									
Бусад эх үүсвэрээс			1,850,000.00						1,850,000
Бусад									
Шилжүүлэн авсан /бүтцийн өөрчлөлтөөр/									
Үндсэн хөрөнгийн устгалаас орлогодсон									
Бусад 2									
Дахин үнэлгээний нэмэгдэл									
ХАСАГДСАН									
Худалдсан									
Шилжүүлсэн /бүтцийн өөрчлөлтөөр/									
Үнэ төлбөргүй шилжүүлсэн									
Акталж, устгасан									
Бусад									
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ (өртөг)		40,893,336.00	33,887,246.54	7,750,542.65			450,000.00		82,981,125.1
Хуримтлагдсан элэгдэл		14,359,132.31	26,260,412.95	2,927,467.27			450,000.00		43,997,012.5
Оны эхний үлдэгдэл									
Өмнөх оны элэгдлийн зөрүү		7,451,832.79	2,003,301.01	864,600.89					10,319,734.6
Зардал									
Шижиж ирсэн хөрөнгийн элэгдэл									
Данснаас хасалт									
Зардал									
Дахин үнэлгээгээр буурсан									
Эцсийн үлдэгдэл (элэгдэл)		21,810,965.10	28,263,713.96	3,792,068.16			450,000.00		54,316,747.22
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		19,082,370.90	5,623,532.58	3,958,474.49					28,664,377.97